



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халхгол сумын Ерөнхий боловсролын 9 жилийн сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2023/169/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Чойбалсан хот 2023 он	Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
	Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Ари файнэнс аудит" ХХК Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.08.24 № 209

танай _____ -ны № _____ -т

Г ХАЛХГОЛ СУМЫН
9 ЖИЛИЙН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.ОЮУНЦЭЦЭГ ТАНАА

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халхгол сумын 9 жилийн сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халхгол сумын 9 жилийн сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол шинжлэх ухааны яам 2022 оноос эхлэн төсвийн шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр Улсын төсвийн хуваарь болон санхүүжилт БШУЯ, БЕГ-аас шууд хуваарилагдан хянагдаж ирдэг болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах зорилгоор энэ хичээлийн жилээс Боловсролын нэгдсэн мэдээллийн систем /esis/-ийн бүх үйл ажиллагаа тухайлбал: багш ажилтан, ажилчдын өөрчлөгдсөн цалин, бусад нэмэгдлүүд,

011020187

холбоо барих мэдээлэл, байршил, үндэсний болон орон нутгийн сургалтад хамрагдсан байдал, сурагчдын үнэлгээ, харьяалал, байршил, асран хамгаалагчийн мэдээлэл, багш нарын цахим журналын шинэчлэл, санхүү, хөрөнгийн мэдээлэл, статистик мэдээлэл зэрэг үйлдлүүд шинэчлэгдэн өөрчлөгдсөнтэй холбогдуулан зохих журам тушаал, шийдвэрийн дагуу цаг хугацаанд нь мэдээллийг оруулснаар мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Энэ нь БШУЯ болон бусад яамдуудын мэдээллийн эх үүсвэр болон ашиглагдаж байгаагаараа онцлог байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	81,019,711.50	208,216,690.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	113,486,431.60
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	113,486,431.60
31210	Төгрөг	-	113,486,431.60
31211	Төрийн сангийн харилцах	-	113,486,431.60
35	БАРАА МАТЕРИАЛ	81,019,711.50	94,730,258.50
35100	Түүхий эд материал	30,193,412.03	31,472,779.03
35110	Тусгай зориулалттай материал	30,121,112.03	31,466,079.03
35130	Эм боох материал	72,300.00	6,700.00
35400	Хангамжийн материал	50,826,299.47	63,257,479.47
35410	Бичиг хэргийн материал	553,500.00	3,546,720.00
35420	Аж ахуйн материал	50,272,799.47	59,710,759.47
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	1,033,302,850.99	1,009,032,135.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,033,302,850.99	1,009,032,135.84
39200	Биет хөрөнгө	1,030,554,850.99	1,006,284,135.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	927,078,131.91	948,923,531.91
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(64,788,334.04)	(103,416,284.48)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	65,499,646.00	78,347,846.00
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(33,878,923.80)	(43,188,893.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,952,993.40	54,125,993.40
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(23,682,534.78)	(31,462,342.55)
39214	Бусад үндсэн хөрөнгө	157,309,517.00	157,309,517.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(47,935,644.70)	(54,992,472.78)
39217	Номын фонд	-	637,241.00
39300	Биет бус хөрөнгө	2,748,000.00	2,748,000.00
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(200,000.00)	(200,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,748,000.00	2,748,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	1,114,322,562.49	1,217,248,825.94
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	1,114,322,562.49	1,217,248,825.94
51	Засгийн газрын хувь оролцоо	1,114,322,562.49	1,217,248,825.94
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	136,093,665.40	136,093,665.40
511001	Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан	136,093,665.40	136,093,665.40
51200	Хуримтлагдсан үр дүн	867,748,499.95	970,674,763.40
51210	Өмнөх үеийн үр дүн	934,057,935.09	(246,574,062.54)
51220	Тайлант үеийн үр дүн	(66,309,435.14)	1,217,248,825.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	110,480,397.14	110,480,397.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	1,114,322,562.49	1,217,248,825.94

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	375,436,799.00	1,703,926,418.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,148,865,770.49
1200	Нийтлэг татварын бус орлого		1,148,865,770.49
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		1,063,935,391.99
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал		84,930,378.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	375,436,799.00	555,060,648.00
1310	Улсын төсвөөс	295,378,900.00	486,143,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		486,143,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	295,378,900.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,255,199.00	4,533,648.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	38,255,199.00	4,533,648.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,802,700.00	64,383,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,802,700.00	64,383,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	441,746,234.14	486,677,592.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441,746,234.14	486,677,592.55
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	392,516,293.14	460,076,819.55
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	245,005,531.00	292,016,497.00
210101	Үндсэн цалин	171,617,814.00	221,398,336.00
210102	Нэмэгдэл	57,564,569.00	56,467,277.00
210104	Урамшуулал	15,823,148.00	14,150,884.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,571,928.00	36,481,510.40
210201	Тэтгэврийн даатгал	22,937,257.84	25,346,168.65
210202	Тэтгэмжийн даатгал	2,539,271.59	2,954,272.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,984,370.47	2,336,536.57
210204	Ажилгүйдлийн даатгал	452,420.12	513,835.78
210205	Эрүүл мэндийн даатгал	4,658,607.98	5,330,697.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,501,129.00	35,526,656.00
210301	Гэрэл, цахилгаан	2,989,641.00	4,420,521.00
210302	Түлш, халаалт	22,964,488.00	29,354,135.00
210303	Цэвэр, бохир ус	1,547,000.00	1,752,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,958,573.20	8,650,170.00
210401	Бичиг хэрэг	1,243,009.00	864,480.00
210402	Тээвэр, шатахуун	123,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	275,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,317,564.20	7,785,690.00
2105	Нормативт зардал	8,449,575.00	18,507,430.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	85,700.00	65,600.00
210502	Хоол, хүнс	8,363,875.00	18,441,830.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,329,020.00	
210604	Урсгал засвар	6,329,020.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	600,000.00	925,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	240,000.00	

Халхгол сумын Ерөнхий боловсролын 9 жилийн сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		925,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,100,536.94	67,969,556.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		5,195,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	658,000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	65,442,536.94	62,774,556.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,229,941.00	26,600,773.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,246,039.00	25,075,998.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,523,335.00	11,784,000.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,084,754.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	9,637,950.00	4,533,648.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		8,758,350.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,301,571.00	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,301,571.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,682,331.00	1,524,775.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,682,331.00	1,524,775.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(66,309,435.14)	1,217,248,825.94
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(66,309,435.14)	1,217,248,825.94

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	375,436,799.00	555,060,648.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	375,436,799.00	555,060,648.00
1310	Улсын төсвөөс	295,378,900.00	486,143,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		486,143,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	295,378,900.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,255,199.00	4,533,648.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	38,255,199.00	4,533,648.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,802,700.00	64,383,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,802,700.00	64,383,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	375,436,799.00	433,702,916.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	375,436,799.00	433,702,916.40
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	325,368,428.00	406,129,293.40
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	245,005,531.00	292,016,497.00
210101	Үндсэн цалин	171,617,814.00	221,398,336.00
210102	Нэмэгдэл	57,564,569.00	56,467,277.00
210104	Урамшуулал	15,823,148.00	14,150,884.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,571,928.00	36,481,510.40
210201	Тэтгэврийн даатгал	22,937,257.84	25,346,168.65
210202	Тэтгэмжийн даатгал	2,539,271.59	2,954,272.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,984,370.47	2,336,536.57

Халхгол сумын Ерөнхий боловсролын 9 жилийн сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	452,420.12	513,835.78
210205	Эрүүл мэндийн даатгал	4,658,607.98	5,330,697.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,501,129.00	35,526,656.00
210301	Гэрэл, цахилгаан	2,989,641.00	4,703,956.00
210302	Түлш, халаалт	22,964,488.00	29,070,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,547,000.00	1,752,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,724,995.00	
210401	Бичиг хэрэг	317,609.00	
210402	Тээвэр, шатахуун	123,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	275,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,209,386.00	
2105	Нормативт зардал	7,294,845.00	18,441,830.00
210502	Хоол, хүнс	7,294,845.00	18,441,830.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	2,986,400.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	2,986,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	720,000.00	2,383,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	360,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		2,383,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,550,000.00	18,293,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		12,932,900.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	3,550,000.00	5,360,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,068,371.00	27,573,623.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,084,469.00	26,048,848.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,361,765.00	11,784,000.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,084,754.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	9,637,950.00	4,533,648.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		9,731,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,301,571.00	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,301,571.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,682,331.00	1,524,775.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,682,331.00	1,524,775.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)		121,357,731.60
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		7,871,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		7,871,300.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		7,871,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		7,871,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)		(7,871,300.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)		113,486,431.60
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		113,486,431.60

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	136,093,665.40	110,480,397.14	934,057,935.09	1,180,631,997.63
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	136,093,665.40	110,480,397.14	934,057,935.09	1,180,631,997.63
9	Тайлант үеийн үр дүн	-	-	2,003,646.36	2,003,646.36
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	136,093,665.40	110,480,397.14	867,748,499.95	1,114,322,562.49
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,114,322,562.49)	(1,114,322,562.49)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	136,093,665.40	110,480,397.14	(246,574,062.54)	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	1,217,248,825.94	1,217,248,825.94
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	136,093,665.40	110,480,397.14	970,674,763.40	1,217,248,825.94

2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	550,527,000.00	435,515,793.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	550,527,000.00	435,515,793.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	528,122,100.00	414,000,593.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	385,739,800.00	292,016,497.00
210101	Үндсэн цалин	279,589,900.00	221,398,336.00
210102	Нэмэгдэл	91,999,000.00	56,467,277.00
210104	Урамшуулал	14,150,900.00	14,150,884.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,221,800.00	36,481,510.40
210201	Тэтгэврийн даатгал	32,790,800.00	25,346,168.65
210202	Тэтгэмжийн даатгал	3,857,700.00	2,954,272.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,086,200.00	2,336,536.57
210204	Ажилгүйдлийн даатгал	771,600.00	513,835.78
210205	Эрүүл мэндийн даатгал	7,715,500.00	5,330,697.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,051,100.00	35,526,656.00
210301	Гэрэл, цахилгаан	6,227,300.00	4,703,956.00
210302	Түлш, халаалт	29,070,700.00	29,070,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,753,100.00	1,752,000.00
2105	Нормативт зардал	21,710,100.00	18,441,830.00
210502	Хоол, хүнс	21,710,100.00	18,441,830.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,986,400.00	2,986,400.00
210604	Урсгал засвар	2,986,400.00	2,986,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,384,200.00	2,383,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,384,200.00	2,383,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,028,700.00	26,164,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,668,200.00	20,804,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,360,500.00	5,360,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,404,900.00	21,515,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,404,900.00	21,515,200.00

Халхгол сумын Ерөнхий боловсролын 9 жилийн сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,673,700.00	11,784,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,731,200.00	9,731,200.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	550,527,000.00	549,002,225.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	550,527,000.00	549,002,225.00
122005	Орон нутгийн төсвөөс	550,527,000.00	549,002,225.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	113,486,431.60

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,533,648.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,533,648.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,533,648.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,533,648.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,533,648.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,533,648.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,533,648.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,533,648.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,670.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 3,670.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

1. Хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1. "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" заалт; 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 17 дугаар зүйлийн 17.1. "Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана", 30.4. "Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана", 30.4.1 "тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах", 30.4.2 "энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах", 30.4.3 "энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах", 34 дүгээр зүйлийн 34.3 "Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. 1. Хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 26,324.4 мянган төгрөгийн хөрөнгө орлогод авах тогтоол гарсан боловч 29,995.0 мянган төгрөгийн хөрөнгө орлогод авч, 3,670.9 мянган төгрөгийн хөрөнгийг тушаал шийдвэргүйгээр орлогод авч бүртгэсэн байна. Энэ нь УСНББОУС-1 санхүүгийн тайлангийн толилуулга, НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1. "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" заалт; 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалтууд, Санхүүгийн тайлангийн "үнэлгээ", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох тушаал шийдвэрийн хүрээнд хөрөнгө бэлтгэж, бэлтгэсэн хөрөнгийг холбогдох шийдвэрийн хүрээнд орлогоор бүртгэх

2. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сурагчдын хоолны санхүүжилтийг esis.edu цахим системд сурагчдын өдөр тутмын ирцийг хөтлөн няравын тайланд бүртгэж тооцоо хийдэггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэж 5 дугаар зүйлийн 5.1.1 Үнэн зав байх гэсэн заалтуудтай нийцээгүй, иж бүрэн, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтаар баталгаажуулж ажил, гүйлгээг бүртгэхгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 26,324.4 мянган төгрөгийн хөрөнгө орлогод авах тогтоол гарсан боловч 29,995.0 мянган төгрөгийн хөрөнгө орлогод авч, 3,670.9 мянган төгрөгийн хөрөнгийг тушаал шийдвэргүйгээр орлогод авч бүртгэсэн байна.	1	3,670.9					1	3,670.9
Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.	1	-			1	-		
Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт ертгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан.	1	-			1	-		
Сурагчдын хоолны санхүүжилтийг esis.edu цахим системд сурагчдын өдөр тутмын ирцийг хөтлөн няравын тайланд бүртгэж тооцоо хийдэггүй	1	-					1	-
Дүн	4	3,670.9			2	3,670.9	2	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэхэд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах 1 мэдээллийг мэдээлээгүй байна.	1	7,142.8			1	7,142.8		
Дүн	1	7,142.8			1	7,142.8		



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 66/1 ДОА-2023/169/НА-СТА-ТШЗ Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын 9 жилийн сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1. "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" заалт; 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.2 "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эд хөрөнгийн тооллого хийгдсэний дараа хөрөнгийн тооцоог бодож, тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулсан байх, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халхгол сумын 9 жилийн сургуулийн захирал Д.Оюунцэцэг, нягтлан бодогч П.Оюунтулга нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ийн
ЗАХИРАЛ

И.СЭМЖИДМАА

Д.АРИУНАА

011040399



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 67/02 ДОО-2023/169/НА-СТА-ТШЗ

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын 9 жилийн сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 17 дугаар зүйлийн 17.1. "Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана", 30.4. "Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана", 30.4.1 "тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах", 30.4.2 "энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах", 30.4.3 "энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах", 34 дүгээр зүйлийн 34.3 "Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

011040401

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, алдаа зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халхгол сумын 9 жилийн сургуулийн захирал Д.Оюунцэцэг, нягтлан бодогч П.Оюунтулга нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР

 И.СЭМЖИДМАА

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

 Д.АРИУНАА



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 68/03 ДОО-2023/169/НА-СТА-ТШЗ

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын 9 жилийн сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэхэд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 7,142,810.00 /долоон сая нэг зуун дөчин хоёр мянга найман зуун арван/ төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4 "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх" заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх", "тасалбар болголт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь байршуулахад тавих дотоод хяналтыг сайжруулж, биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халхгол сумын 9 жилийн сургуулийн захирал Д.Оюунцэцэг, нягтлан бодогч П.Оюунтулга даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ийн
ЗАХИРАЛ

Д.АРИУНАА



011040404